



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.06.20 № 7/2552
танай _____-ны № _____-т

Хүсэлтийн хариу хүргүүлэх тухай

Танай компанийн “Nsf.mn” аппликэйшнийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх хүсэлтийг Цахим зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн цахим хуралдаанаар хэлэлцэн журмын технологийн шаардлагыг хангасан гэж дүгнэж, үйл ажиллагаа явуулах боломжтой финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэж цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1.Танай компанийн зээлийн хүүгийн хэмжээ нь өдрөөр илэрхийлэгдэж байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.1-т “зээлийн бүтээгдэхүүн, зориулалт, жилийн хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг нийтэд ил тод мэдээлдэг байх;”;

2.Зээлийн гэрээний хугацааг хоёр болон түүнээс дээш удаа сунгах тохиолдолд ангилал бууруулахгүй байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 998 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.5-д “Активын гэрээний хугацааг нэг удаа сунгасан бол ангиллыг хэвээр хадгална, харин хоёр болон түүнээс дээш сунгасан бол өмнөх ангиллаас нэг шатлалаар бууруулна.” гэж заасан заалтуудад нийцэхгүй байгааг анхаарч хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн Санхүүгийн зохицуулах хороонд 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө гүйцэтгэлийг ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА



Б.ИТГЭЛСҮРЭН